

МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТЫН ХАНДЛАГА

З.Ядмаа

ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургууль

e-mail: yadmaa_z@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГ: мах, ноос ноолуур, арьс шир

ОРШИЛ

Олон улсын бизнесийн цар хүрээ өдөр ирэх тутам өргөжих боллоо. Бизнесийн үйл ажиллагаа өргөжих олон шалтгаан байсан нь тухайн улс орны үнэмлэхүй болон харьцангуй давуу талтай холбоотой. Харьцангуй давуу тал нь зарим орнуудад барааны үйлдвэрлэл илүүдэж, заримд нь хомсдож, тухайн бүтээгдэхүүний бэлэн зах зээлийг бий болгодог. Тухайн улс нь өөртөө хамгийн элбэг байдаг хүчин зүйлсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж улмаар экспорт хийх нь ашигтай байдаг. Монгол улсын хувьд эхний ээлжинд эдийн засгийн хувьд хамгийн өгөөжтэй, экспортлоход ашигтай байгаа мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ач холбогдолтой юм. Гэхдээ зөвхөн түүхий эдийн барааны экспортыг хөгжүүлснээр эдийн засгийн өгөөж нь хүссэн хэмжээнд хүрдэггүй гэдгийг ойлгож хөгжих ёстой.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас ихээхэн хамааралтай бөгөөд хөдөө аж

ахуйн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэлийг явуулахад гол түүхий эд болдог онцлогтой.

Монгол улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, нэгдэл, сангийн аж ахуй татан буугдаж, малыг малчдад хувьчилсанаар хөнгөн аж үйлдвэрийн салбар уналтад орж гадаад худалдаанаас олох орлого буурч эхэлсэн билээ. МАА-н гаралтай бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах, аж үйлдвэрийг дотооддоо хөгжүүлэхийн зэрэгцээ гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулснаар улс орны эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлэх, олон улсын худалдаанд ч эерэг хандлага үүсэх ёстой. Иймд энэхүү судалгааны зорилго нь мал аж ахуйн салбарын гол бүтээгдэхүүн болох мах, ноос ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн өнөөгийн байдлыг судлаж тэдгээрийн экспортыг нэмэгдүүлэх талаар санал дэвшүүлэхэд оршино.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хандлагыг мах, ноос ноолуур болон

арьс ширэн дээр судлав. Судалгаагаа салбарын статистикийн үзүүлэлтүүд, хөдөө аж ахуйн

гаралтай бараа, түүний эдийн бирж, олон улсын байгууллагын тоо мэдээллүүд дээр тулгуурласан юм. Тоо мэдээллүүдийг Microsoft Office 2013-н

хүрээн дэх хэрэглээний програм, SPSS программыг ашиглаж гүйцэтгэлээ.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөөс харахад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хурдтай өсөлтөөс шалтаалан ДНБ-д эзлэх ХАА-н салбарын хувийн жин буурч байна. ДНБ-д эзлэх үйлдвэрлэлийн салбарын хувь эрчимтэй өсч байгаад уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн салбарын өсөлт голлон нөлөөлжээ. ХҮХХААЯ-ны статистикаас харахад 2012 оны байдлаар манай улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 14.6 хувь, экспортын орлогын 7.0 орчим хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын орлого 213.8 сая ам.доллар [3] болсон байна. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2012 оны урьдчилсан гүйцэтгэлээр, оны үнээр 1906.0 тэрбум төгрөг, 2005 оны зэрэгцүүлэх үнээр 957.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 29.1 хувь, зэрэгцүүлэх үнээр 24.4 хувиар [1] өссөн байна. Монгол улсын нийт ажиллах хүчний

35.0 % [3] нь энэ салбарт ажиллаж байна. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын 52.1%-ийг мах, махан бүтээгдэхүүн, 41.5%-ийг сүлжмэл бүтээгдэхүүн, 6.4%-ийг [1] бусад төрлийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Мах үйлдвэрлэл

Дэлхийн хэмжээнд 19 нэр төрлийн 229.3 сая тонн мах [4] үйлдвэрлэгдэж байна. Үүнээс 44 нэр төрлийн 54.5 тэрбум долларын 25.0 тонн мах, махан бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр борлогддог.

Дэлхийн махны экспортыг сүүлийн 4 жилийн дунджаар авч үзвэл 2.1 сая тонн таван хошуу малын гаралтай мах экспортлогдож байгаагийн 55 хувь нь үхэр, тугалын мах, 38 хувь нь хонь хурганы мах, 6 хувь нь ямааны мар байгаа бөгөөд, харин дэлхийн зах зээлд тэмээний мах экспортлогдодгүй.



1-р зураг. Дэлхийн мах үйлдвэрлэлийн бүтэц

Дэлхийн махны экспортын хандлагаас харахад үхрийн болон хонины махны экспортын хэмжээ өсөх хандлагатай байна. Манай улсын мал аж ахуйн салбарт 2012 онд нядалгааны жингээр 220.4 мян.тонн мах үйлдвэрлэж, үүнээс үхрийн хөлдүү мах 965.1 тонн, хонь ямааны мах 675.1 тонн, адууны мах 1462.1 тонн, дайвар бүтээгдэхүүн 821.2 тонн [3] тус тус экспортолсон байна. Ойролцоогоор бэлтгэсэн махны 2%-экспортонд гаргаж байна. Адууны

махны хувьд үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн махны экспортын хэмжээг өсгөх боломж нээлттэй байна. Түүхий мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд манай улсын мал гоц халдварт өвчлөл, мал эмнэлэгийн үйлчилгээний систем зэрэг хүчин зүйлүүд сөргөөр нөлөөлдөг. Гэтэл түүхий махны гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээ асар өндөр байгааг бид ойлгож энэ боломжийг ашиглах ёстой.

Ноос, ноолуур үйлдвэрлэл

Дэлхийн түүхий ноосны хэрэглээгээр БНХАУ, Япон, Итали зэрэг улсууд тэргүүлж байгаа бол түүхийн ноосны экспортоор Австрали, Шинэ Зеланд, Аргентин зэрэг улсууд тэргүүлж байна.

Дэлхийн ноосны зах зээлийн хандлагаас харахад сүүлийн жилүүдэд түүхий ноосны үнэ болон экспортын хэмжээ буурах хандлагатай байгаа ч 2011 оноос хойш экспортын хэмжээ 1-2%-иар [4] өсөж байна.



2-р зураг. Дэлхийн ноос үйлдвэрлэгч гол улс

Дэлхийн ноолуурын экспортын гол өрсөлдөгчид бол Хятад, Монгол, Иран, Афганистан, Пакистан, Энэтхэг, Шинэ Зеланд, Австрали, Казакстан болон Таджикистан зэрэг улс орнууд байна. Манай улсын хувьд жилд дунджаар 20 мянган тонн хонины ноос, мянган тонн орчим тэмээний ноос, 5 мянга гаруй тонн ямааны

ноолуур үйлдвэрлэж ноосны 23%, ноолуурын 70%-ийг [1] [3] экспортод гаргаж байна. Ноос, ноолуурын үндэсний хэмжээний томоохон компаниудын үйлдвэрлэлийн хэмжээ өсөж байгаа боловч экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, борлуулах зах зээлийг тэлэхэд төрийн дэмжлэг чухал байна.



3-р зураг. Ноос, ноолуур үйлдвэрлэл (2000-2012 он)

Хонины ноосны хувьд 91.7 хувь нь Монгол хонины бүдүүн ноос эзэлж байгаа бөгөөд нарийн нарийвтар ноос 30 орчим тонныг, бүдүүвтэр ноос 2000 орчим тонныг [3] бэлтгэж байна. Дэлхийн зах зээл дээр нарийн, нарийвтар ноосны эрэлт их байдгийг бид анхаармаар байна. Угаасан ноос, ноолуур зөвхөн Хятад руу экспортод бол самнасан ноолуурын экспортын 70-80⁴ хувийг Хятад, Итали улс эзэлдэг. Ноос ноолууран бэлэн бүтээгдэхүүний экспорт нь ноос ноолуурын нийт экспортын 20-30 хувь байдаг. Эндээс Монголын ноос, ноолуурын экспорт үндсэндээ, түүхий эд дээр

түшиглэдэг болох нь, түүний дотор Хятад улс руу чиглэдэг болох нь тодорхой харагдаж байгаа болно. Ноолууран олон бүтээгдэхүүнийг дэлхийн 20-иод оронд экспортолж байгаа боловч тоо, хэмжээ нь хангалттай биш юм. Тиймээс ч бид Европын Холбооноос манай улсад үзүүлж байгаа “тарифын хөнгөлөлт”-ийг одоо болтол олигтой ашиглаж чадахгүй байна. Монгол улсын хивс болон ноосон бүтээгдэхүүний экспортын орлого өсөх хандлагатай байгаа боловч нийт экспортод эзлэх хивс болон ноосон бүтээгдэхүүний экспорт 1996-2011 оны хооронд 1%-3% хооронд хэлбэлзэж байна.

Арьс ширний үйлдвэрлэл

Дэлхийн арьс ширний үйлдвэрлэлийн 60%-ийг [4] хөгжиж байгаа улс орнууд эзэлж байгаа бол үхрийн боловсруулсан ширний экспортын

хэмжээгээр АНУ, Европын холбоо, Бразил, БНХАУ зэрэг улсууд тэргүүлж байна. Австрали, Шинэ Зеланд зэрэг улс орнууд хонь, ямааны боловсруулсан арьсны экспортын хэмжээгээр тэргүүлэх байр суурь эзэлж байна.



4-р зураг. Дэлхийн арьс ширний үйлдвэрлэлийн бүтэц

Арьс ширний экспортлогч 15 томоохон улсын арьс ширний экспорт огцом өсч байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр орнуудын арьс ширэн бүтээгдэхүүний экспортын жилийн өсөлт нь ойролцоогоор 17% байна. Манай улсын хувьд 2012 оны байдлаар 8.8 сая ширхэг [1] [3] арьс шир үйлдвэрлэсэн байна. Үүний 52.4 хувийг хонины арьс, 26.2 хувийг ширхэгийг ямааны арьс, 7.1 хувийг үхрийн шир, 4.7 хувийг адууны шир, 4.8 хувийг бусад төрлийн арьсан түүхийг эд эзлэж байна. Адууны ширний хувьд 81.6%-ийг экспортод гаргаж байна. Манай улсын арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн дийлэнх нь бага буюу дунд оврын тоног төхөөрөмжтэй боловч гүн боловсруулалтын тоног төхөөрөмжтэй үйлдвэрүүд цөөхөн, техник технологийн түвшин хангалтгүй байна. Мөн

малын арьс ширний амьдын гэмтлүүд буурахгүй байгаагийн зэрэгцээ нядалгааны болон нядалгааны дараах түүхий эдийн чанарын үзүүлэлт хангалтгүй байна. Энэ нь эцсийн бүтээгдэхүүний чанарт муугаар нөлөөлдөг төдийгүй боловсруулалтын зардлыг ихээхэн нэмэгдүүлэхэд хүргэдэг. Олон улсын хэмжээнд ашиглагддаг чанарын үзүүлэлтийн дагуу Монгол малын арьс шир сүүлийн ангилалд багтаж байна. Сүүлийн жилүүдэд дотоодын арьс ширний үйлдвэрлэлийг дэмжиж арьс ширний нийлүүлэгчдэд урамшуулал олгох, арьс ширний цогцолбор үйлдвэрлэлийн бодлого зэрэг шийдлүүд бий болж байна. Гэхдээ бидний өөрсдийн давуу талыг ашиглах үйл явц удаашралтай байна.

ДҮГНЭЛТ

Манай улс жил бүр 25 мянган тонн орчим хонины ноос, 6 мянган тонн ямааны ноолуур, 960 тонн бодын хөөвөр, 1000 тонн тэмээний ноосыг тус тус бэлтгэх боломжтой. Гэхдээ мах экспортлох нөөц боломжийнхоо 10 хүрэхгүй хувийг ашиглаж байна. Түүнчлэн манай улсын гадаад худалдааны бодлого оновчтой бус байгаагаас экспортлогчдод бусад улс орны гаалийн тарифын болон худалдааны нөхцлүүд ихээхэн хүндрэл учруулж байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг

нэмэгдүүлэхийн тулд дараахь саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж махны экспортын хэмжээг нэмэгдүүлэх;
2. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх замаар улсын төсөвт татварын хэлбэрээр орох валютын орлогыг нэмэгдүүлэх;
3. Түүхий эдийг иж бүрэн боловсруулах замаар экспортыг нэмэгдүүлэх ажлуудыг ээлж дараатайгаар зохион байгуулах;

4. Төрөөс мал аж ахуйн түүхий эдийг орон нутагт боловсруулж, хөрш зэргэлдээ гадаад орнуудтай шууд харьцах, бүтээгдэхүүнээ тэдний зах зээлд шууд гаргах;
5. Мал аж ахуйн салбарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах, зээл, татварын бодлогоор дэмжих;
6. Сүү үйлдвэрлэлийн хувьд хөргөлтийн төвүүдийг байгуулах замаар сүүний үйлдвэрлэлийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлснээр сүүний импортыг бууруулах;
7. Ноос ноолуур боловсруулах үйлдвэрийн салбарт тодорхой нэмүү өртөг шингэсэн шат дамжлагыг нэмэгдүүлж дэлхийн зах зээлийн шаардлагад нийцсэн монголын ноолууран бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх шаардлагатай байгаас гадна түүхий ноолуурыг экспортлохоос зайлсхийх;
8. Арьс шир боловсруулах үйлдвэрүүдийн техник технологийг шинэчлэх замаар хүчин чадлаа нэмэгдүүлж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох;
9. Зах зээлийн үед хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг нийлүүлдэг түүхий эдийн биржийн сонгодог загварыг бий болгож уг салбарт туршин нэвтрүүлэх замаар малын гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох гадаад зах зээлээ өргөжүүлэх;
10. Дээрх арга хэмжээнүүдийг авснаар ХАА-н салбарын ДНБ-нд эзлэх хувь хэмжээг 40%-д хүргэх.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол улсын статистикийн эмхтгэл МУҮСХ 2002-2010 УБ
2. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж- товхимол УБ 2011 он
3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын статистик үзүүлэлтүүд 2012 он
4. www.fao.com

ABSTRACT

Livestock husbandry is a special, traditional sector of the national economy, and an important source of employment and export income for Mongolia. The discussion offers suggestions on how to improve the Mongolian export situation. Today the agriculture sector employs around 34% of the total labor force and produces 13% of all GDP, of which 85% is from livestock production. The livestock industry earns around 4% of all export income. The export of livestock products in Mongolia consists of meat and meat products (52.1 percent), garments (41.5 percent) and other products (6.4 percent). During last three years, the share of agricultural products in the Gross Domestic Products (GDP) has decreased from 18 percent to 13 percent. Mongolia exports its products to 66 countries in the world, thus Peoples Republic of China accounts 84.8 percent, Russian Federation 2.8 percent and Canada 4.9 percent in the total export respectively.